

## ЖИЛИНЬ МУЖИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ

Д.ЗОЛБОО\*

2001 он бол Манай хүрээлэнгийн гадаад амьдрал олон чухал үйл явдлаар баялаг жилийн нэг байлаа. Эдгээрийн нэг нь өмнөд хөрш БНХАУ-ын эрдэм шинжилгээний байгууллагуудын нэг Чанчун хот дахь Нийгмийн ухааны академи, Зүүн хойт Ази судлалын хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээгээ сэргээж, байгууллагуудын удирдлагууд харилцан айлчилсан бөгөөд энэ шугамаар судлаач, мэргэжилтэн солилцох, хамтран судалгааны ажил хийх талаар харилцан тохиролцсон билээ. Jilin ( 吉林省 ) мужийг манай ном хэвлэлд ихэвчлэн Гирын муж гэж бичдэг бөгөөд орос галигаар Зилинь гэх нь ч бий. Энэ удаад Жилинь мужийн талаар цуглуулсан сүүлийн үеийн материалуудаа тулгуурлан энэхүү мужийн хөгжлийн өнөөгийн төлөвийн талаар цухас дурьдах болно.

Зүүн хойт Азийн бүс нутагт БНХАУ-ын Хар мөрөн, Ляонин, Жилинь муж, Өвөр Монголын өөртөө засах орны зүүн хойт бүс, нийслэл Бээжин хот, түүний ойр орчим болон далайн томоохон боомт хот Тяньжин багтана. Харин БНХАУ-ын зүүн хойт бүс нутаг гэдэгт зөвхөн дээрх гурван мужийг оруулан авч үздэг байна.

Энэ гурван муж нь сүүлийн хэдэн жилд эдийн засгийн хөгжлийн хурдсаараа өөрийн орондоо төдийгүй бүс нутгийн хэмжээнд нөлөө үзүүлэх хэмжээнд хүрэхүйц болжээ.

Зүүн хойт Хятадын төв дунд орших газрын зураг дээр “атийсан бар” шиг хэлбэртэй харагдах Жилинь муж нь гурван улсын хилийн уулзварт байрлан, зүүн талаараа ОХУ-тай хиллэх ба зүүн өмнөд хэсэг нь Солонгосын хойгоос Түмэн гол ба Яалу голын дагуу зааглагдана. Далайд хамгийн ойрхон газар нь Түмэн голын дагуу 15 километрийн зайтай Япон тэнгис оршино.

Нийт 9 тойрог, 41 суурин, 28 суурин газар, 19 дүүргээс бүрдсэн 187 мянган хавтгай дөрвөлжин газар нутагтай. Хүн амын тоо нь 2000 оны эцсийн байдлаар 27.3 сая байснаас хан, хотон, солонгос, манж, орос, монгол үндэстэн голлон оршин суудаг байна.

Үүнийхээ дагуу энэ мужид үндэстний цөөнхийн 4 автономит район буюу бүс нутаг байдаг байна. Эдгээр нь:

1. Янбяны Солонгос үндэстний автономит район ( 延邊朝鮮自治州 )
2. Хуучин Орос үндэстний автономит район ( 前郭爾羅斯自治縣 )

\* Д.Золбоо - ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

3. Чанбайн Солонгос үндэстний автономит район (長白朝鮮族自治縣)
4. Итуний Манж үндэстний автономит (伊通滿族自治縣) район юм.

Мужийн нийслэл нь эртний соёлын дурсгалт газар болох Чанчун хот юм. Сүүлийн жилүүдэд дэд бүтцийн салбарыг онцгой анхааран хөгжүүлсэнээр хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхэд гайхалтай хүчин зүйл болж байна. Төмөр замын болон хурдны авто замын сүлжээ мужийн нийт нутгаар бүрэн тавигдсан.

Улсын чанартай төмөр замын зэрэгцээ Жилин муж өөрийн хүчээр Түмэнт хотоос Хунчун хүртэл орон нутгийн чанартай төмөр замыг барьж байгуулсан бөгөөд энэ нь хэгийн төлөвлөгөөний дагуу ОХУ-ын Алс дорнод, Сибирийн төмөр замтай нийлэх юм. Төмөр замын нийт урт 3780 км байдаг нь Хятад улсдаа 3-рт орох хэжмээ юм.

Мужийн хэмжээнд нийтдээ 32100 км урт замаар бүх хот, суурин газар болон хөрш зэргэлдээ мужуудтай холбогддог байна. Хурдны буюу тууш замын зэрэглэл, чанарын түвшин байнга дээшилсээр байгаа бөгөөд одоогоор 542 км урт замтай болоод байна. Бээжин - Харбины чиглэлийн хурдны замын нэгэн хэсэг болсон Чанчун - Сипиний зам нэгэнт ашиглалтанд орсон байна.

Жилин мужид нийтдээ 21 боомт хот байдгаас 16 нь Хятад болон БНАСАУ-ын хил, 2 нь Хятад болон ОХУ-ын хилийн шугам дээр байрлах ба үлдсэн 3 нь Чанчун дахь Нисэх онгоцны буудал, Төмөр замын буудал болон Даяаны гэсэн дотоодын боомт юм. Эдгээрийн 12 нь үндэстний хэмжээний А зэрэглэлтэй, 5 нь орон нутгийн Б зэрэглэлтэй, 4 нь олон нийтийн болон бараа тээвэрлэлтийн зориулалтай юм.

Чанчун, Жилин, Люхэ, Янжи-гийн онгоцны буудал нь мужийн нүүр царайг ерөнхийд нь тодорхойлж чадахуйц билээ. Одоогоор эдгээр буудлаас орон нутгийн нислэгээс гадна Хонгконг, Владивостокт байнгын нислэгтэй бөгөөд Сөүл, Сендай, Нигата, Эрхүү болон Минск хотод ачаа тээврийн нислэг хийх бололцоотой.

Жилин нь хэдийгээр далайд гарцгүй мужуудын нэг боловч энэ мужийн эдийн засагт далайн усан тээвэр эрхэлдэг компаниудын хүчин туслалцаа их юм. Дотоодын гол, мөрний 660 км урттай 5 чиглэлийн усан замтай. Эдгээр боомтын жилийн бараа эргэлтийн хэмжээ 1.8 сая тоннд хүрдэг байна. Үүний зэрэгцээ Далянь - Инкоугийн хооронд далайн тээврийн 3 шинэ чиглэл нээгдсэн бөгөөд энэ нь: Хунчун-Посейт-Владивосток-Пусан, Түмэн-Чунжин-Японы баруун эрэг, Хунчун-Лажин-Пусан юм.

Гар утас болон хөдөлгөөнт холбооны үйлчилгээ томоохон хотуудад нэлээд нэвтэрсэн. 2000 оны эцсийн байдлаар үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2.03 сая, пейжер хэрэглэгчдийн тоо 1.56 сая, харин

интернэт хэрэглэгчдийн тоо 256 мянгад нэгэнт хүрчээ.

Жилин муж нь байгалийн түүхий эдээр нэн баялаг. Хэн бүхний сайн мэдэх газар тариалангийн томоохон үйлдвэрлэлээс гадна Хятадын буудай боловсруулалтын хамгийн гол цэгийн нэг ба 1 жилийн бүх ургацын хэмжээ 20 сая тонн хүрдэг байна. Буудайн боловсруулат, ялангуяа эрдэнэ шишийн бололцоо асар их юм. Жилин мужийн Чанбай уул болон Их Хянганы уулс нь ой модны асар их нөөц баялагтай бөгөөд модны нөөц болон мод боловсруулалтаараа улсдаа хоёрдугаарт ордог байна. Мужийн баруун хэсэг дэх Му минь, Бай чэний хээр тал нутаг нь мал аж ахуй болон махны үйлдвэрлэл эрхлэхэд тааламжтай өргөн уудам нутагтай юм. 3000 гаруй нэр төрлийн амьтны болон ургамалын гаралтай түүхий эд нь эдийн засгийн хувьд асар их үнэ цэнэтэй бөгөөд эдгээрээс “Зүүн хойт нутгийн 3 эрдэнэ” хэмээн алдаршсан хүн орхоодой, бугын эвэр, булганы сор нь анагаах ухаан болон цагаан хоолтны үнэт материал болдог юм. Жилин нь байгалийн хийн болон газрын тосны арвин нөөцтэй ба зүүн хэсгийн уулархаг бүс нь ундны усны баялаг нөөцтэй, баруун хэсгийн тал хээрийн бүсийн салхины хүчийг ашиглах нь эрчим хүчний үйлдвэрлэлийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг юм. Энэ бүс нутагт 130 гаруй эрдэс бодис, ашигт малтмалын төрөл олоод байгаагаас 83-г нь нэгэнт ашиглаж байна.

Жилин муж нь үйлдвэрлэлийн найдвартай суурь баазтай ба Хятадын уламжлалт үйлдвэрлэлийн бүс нутгийн нэг юм. Улсын мэдлийн их ба дунд зэргийн үйлдвэрийн газрын нийт тоо нь 640-өөс илүү болсон байна. Чанчун хот дахь авто машины FAW үйлдвэр нь Хятадын машин үйлдвэрлэлийн өлгий болсон газар юм. “Liberation” ачааны тэрэг, “Redflag” хөнгөн тэрэг зэргийг FAW-д үйлдвэрлэдэг ба FAW-Wolkswagon-ий хамтарсан үйлдвэрийн “Audi”, “Jetta” тэргүүд нь эх орондоо төдийгүй гадаадын зах зээл дээр ч гэсэн өндөр нэр хүндтэй билээ. Жилиний Химийн үйлдвэрлэлийн корпораши нь Хятад дахь галт тэрэгний зүтгүүр үйлдвэрлэлийн нэг гол төв юм. Ерөнхийдөө энэ бүгдээс аваад үзвэл Жилин нь автомашин, модон эдлэл болон боловсруулах үйлдвэрлэл зэргийг хослуулсан бүрэн үйлдвэрлэлийн системийг барьж байгуулж байна. Тиймээс ч автомашин, галт тэрэгний зүтгүүр, трактор, нүүрс олборлолт, химийн үндсэн түүхий эд, мод болон машинаар хийсэн үйлдвэрлэлийн цаас зэрэг нь улсын хэмжээнд чухал байр суурь эзэлдэг юм.

Жилин муж нь дээд боловсрол, мэргэшсэн боловсон хүчний хангалттай нөөцтэй бөгөөд, жилинийхэн эрдэм шинжилгээний судалгаа болон боловсролыг тэргүүн зэрэгт тавьдаг. Чанчуний Гэрэл судлалын хүрээлэн ба машин судлал, хэрэглээний хими судлалын хүрээлэн зэргээс гадна олон тооны үндсэн судалгааны хүрээлэн, Зүүн хойт бүсийн Их Сургууль, Жилиний Технологийн Их Сургууль, Жилиний Их Сургууль

зэргийг энд дурьдаж болох юм. Тиймээс энэ муж нь 100.000 хүнд оногдох мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүний тоогоор улсдаа 5-рт ордог байна.

Энэ муж нь жуулчлалын асар баялаг бололцоотой. Чанбай уулын байгалийн цогцолбор газар. Сяньхайн байгалийн дархан цаазат газар, Сунхуа нуур болон Жинюе усан цөөрөм, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарлан албан ёсоор хамгаалалтанд авсан экологийн хамгаалалтын бүс нутаг болох Улаан тогорууны дархан цаазат газар, Жилин хот дахь Буурал хяруут модол зэрэг гадны жуулчдын очих дуртай олон сайхан газар бий. 2000 онд 222700 жуулчин ирсэн нь өмнөх онтой харьцуулахад 40,1%-аар өссөн үзүүлэлт бөгөөд мужийн хэмжээнд оруулах орлогын хэмжээ 28,9 %-аар өсч 58 сая \$-д хүрсэн байна. ❄

Жилин мужил мөн зах зээлийн ихээхэн багтаамж бий. Энэ муж нь Хятадын төдийгүй Зүүн хойт Азийн төв дунд оршдог нь өргөн хэрэглээний бараа болон дамжин өнгөрөх худалдааны төв цэг болж болох юм. Хятад улсын Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэн орох хүчин чармайлт, хүмүүсийн амьдралын төвшний дээшлэлт зэрэг нь бүс нутгийн зах зээлийн эрэлт хэрэгцээг улам бүр нэмэгдүүлж байна. Түмэн голын бүсээс эхэлсэн энэхүү олон улсын хөгжил дэвшил нь ОХУ-ын Алс Дорнод, Солонгосын хойг болон Монголыг хамрах нь гарцаагүй юм. Зах зээл гэдэг бол хөгжлийн хамгийн гол тулгуур хүчин зүйл билээ.


1999 онд Жилиний дотоодын нийт бүтээгдхүүний хэмжээ 166.95 тэрбум юаньд хүрсэн ба энэ нь үндэстний дунджаас 1.4% өндөр байгаа юм. Мужийн хувьд гэхэд дэлхийн 130 оронтой худалдааны харилцаатай төдийгүй 100 гаруй худалдааны болон ашгийн бус байгууллагатай харилцаатай болсон байна. Жилиний экспортын хэмжээ 2000 онд 25 хувиар өсч 1.5 тэрбум долларт хүрснээс 44%-г нь хөнгөн үйлдвэрлэлийн бараа бүтээгдхүүн эзэлдэг байна. Экспортын голлох түнш нь Япон, АНУ, Гонконг, Өмнөд болон Умард Солонгос юм байна. Гол бүтээгдхүүн нь хатаасан банан, хүнсний ногоо, авто машин, гангиг, оёмол бүтээгдхүүн, төмөр эдлэл, цемент болон хөлдөөсөн үхрийн мах зэргийг нэрлэж болох юм. Импортын хэмжээ нь өмнөх онтой харьцуулахад 15,4 %-иар өссөн бөгөөд Герман, Япон, АНУ, Итали, Өмнөд Солонгос зэрэг улс орноос машин техникийн сэлбэг хэрэгсэл, бордоо, хромын хүдэр болон тоног төхөөрөмж голлон оруулжээ.

Гадаадын хөрөнгө оруулагчид, бизнесмэнүүдийн анхаарлыг ихээхэн татаж байгааг хэрэгжүүлж буй төслүүдээс нь бэлээхэн харж болох юм. Үүнд, газар тариаланд 9, автомашины үйлдвэрлэлд 17, газар тариалангийн бүтээгдхүүн болон түүний боловсруулалтын чиглэлээр 30, өндөр болон шинэ технологи нэвтрүүлэхэд 20, хотын аж ахуй

сайжруулахад 12, эрчим хүч болон нийтийн тээврийн чиглэлээр 4, үндсэн хөрөнгө, худалдаа үйлчилгээний бизнест 34, бусад үйлдвэрлэлд 25 төсөл хэрэгжүүлж байгаа талаар тодорхой мэдээллийг сүүлийн үеийн хэвлэлээс харж болох юм. Гадны хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд нь ихэвчлэн тусгайлан зөвшөөрсөн газар тухайлбал Эдийн засаг, технологи хөгжлийн бүс (Economic & Technological Development Zones)-д байрладаг байна. Жилинд 4 улсын чанартай, 13 мужийн чанартай бүс байдаг.

1. Чанчуны эдийн засаг технологи хөгжлийн бүс (長春經濟技術開發區) 1993 онд Төрийн зөвлөлөөс байгуулсан. Гадаадын хөрөнгө оруулагчид үндсэн 4 салбарын үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байна. Үүнд: авто машины үйлдвэрлэл, хөдөө аж ахуй болон бүтээгдхүүн боловсруулалт, цахилгаан бараа болон химийн боловсруулах үйлдвэр юм. Гадны хөрөнгө оруулагчдын ихэнх нь АНУ, Герман, Англи болон Италийнх байдаг байна.
2. Чанчуны шинэ-өндөр технологи хөгжлийн бүс 長春高新技術經濟開發區 1992 онд Төрийн Зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан энэхүү бүсэд нийтдээ 1 тэрбум \$-ийн хөрөнгө бүхий 247 гадны хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд байгаагаас голлон химийн үйлдвэрлэл, микро электроникс, эмийн үйлдвэрлэл, биологийн инженерчлэл, авто машин болон сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэлээр голлон ажилладаг байна.
3. Хунчун хилийн боомтын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (渾春邊境經濟合作區). ОХУ болон БНАСАУ-ын хилийн зааг хэсэгт орших энхүү бүс нь 1992 онд Төрийн зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан ба экспорт, үл хөдлөх хөрөнгө, жуулчлалын салбар түлхүү хөгжсөн.
4. Жилиний шинэ өндөр технологи хөгжлийн бүс (吉林高新技術經濟開發區) юм.

### Жилин мужийн газрын зураг.



## Томоохон хотуудын эдийн засгийн үзүүлэлтүүд (1999)

Хотын нэр	Хүн ам (сая)	ДНБ (тэрбум юань)	Үйлдвэрлэлийн бүтээгдхүүн (тэрбум юань)	Жижиглэн худалдаа (тэрбум юань)
Чанчун 长春	6,912 (+0.6%)	70.7 (+16.1%)	59.7 (+18.7%)	26.5 (+11.3%)
Жилин 吉林	4,300 (+0.6%)	35.2 (+6.3%)	34.1 (+10.7%)	15.7 (+9.0%)
Сипинг 四平	3,223 (+0.5%)	16.4 (+3.8%)	7.1 (+7.6%)	5.9 (+0.0%)
Сунгюань 松原	2,720 (+1.2%)	14.8 (+8.8%)	8.2 (+15.5%)	4.2 (+10.5%)
Тонхуа 通化	2,260 (+0.0%)	13.0 (+5.7%)	8.9 (+1.1%)	5.0 (+5.3%)
Байшан 白山	1,323 (+0.4%)	7.8 (+5.4%)	5.7 (+14.0%)	3.4 (+6.3%)

Жич: ( )-д тэмдэглэсэн нь өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

## Эдийн засгийн гол үзүүлэлт.

Эдийн засгийн үзүүлэлт	1999		2000	
	Хэмжээ	өсөлт	хэмжээ	өсөлт
Газар нутаг (км <sup>2</sup> )	187.400		187.40	
Хүн ам (сая)	26.6	0.5	27.3	2.6
Дотоодын нийт бүтээгдхүүн (ДНБ) /тэрбум юань/	167.0	6.8	183.1	9.0
Нэг хүнд оногдох ДНБ /юань/	6.302	6.2		
Жижиглэн худалдаа /тэрбум юань/	73.4	7.9	81.1	10.5
Ханш уналт /инфляш/	-3.3		-1.4	
Экспорт /тэрбум доллар/	1.2	9.9	1.5	25
Импорт /тэрбум доллар/	1.3	21.8	1.5	15.4
Гадны шууд хөрөнгө оруулалт				
- төслийн тоо	355	-3.3	363	3.3
- гэрээний өртөг /тэрбум доллар/	0.5	-9.1	0.6	32.6
- хэрэгжсэн өртөг /тэрбум доллар/	0.3	-26.4	0.3	11.9

## Ашигласан материал

"Jilin jingji 2000 nian" Chanchun 2001

"Jilin yu Dongbeiyi jingji he zuo yu 2001 nian", Chanchun 2001

China Statistical yearbook 2000, Beijing 2000

Jilin Statistical yearbook 2000, Chanchun 2000

<http://www.tdctrade.com/mktprof/china/jilin>

<http://www.jl.org/jilin/index.html>

<http://www.jilin.gov.cn/en>

<http://www.maps-of-china.com/>